

**Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын
арга хэмжээ**

**ЭРХ ХАСАХ ЯЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ
A COMPARATIVE STUDY OF PRINCIPAL PENALTIES**



Э.Батбаяр

*Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор,
доктор (Ph.D), дэд профессор, хурандаа*

Харьцуулсан судлал нь эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, ял түүний мөн чанар, зорилго, төрөл, хэлбэрийг зөв танин мэдэх, Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сургалтыг чанаржуулах, хуульчдын мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх зэрэгт өндөр ач холбогдолтой судалгааны сэдэв болжээ.

Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал хэрхэн яаж үүссэн, түүний ач холбогдол, арга зүй, онолын үндэслэл зэргийн талаар “торгох ялын харьцуулсан судлал” гэсэн сэдэвт дэлгэрэнгүй авч үзсэн тул энд давхцал үүсэхийг үгүйсгэхгүй учир түүнээс тодруулж үзэхийг зөвлөж байна.

Эрх хасах ялын талаар гадаадын улс орнууд хэрхэн хуульчлан зааж байгаа талаар харьцуулан судалбал, тухайлбал, Үүнд:

- **Швейцарын** Эрүүгийн хуульд “тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, арилжаа эрхлэх, архидан согтуурагчийг ресторан, баараар үйлчлүүлэхийг хорих, эрх мэдэлтнийг албан тушаалаас халах, эцэг, эх, асран хамгаалагч байх эрхийг хасах” гэсэн нэмэгдэл ялуудыг хэрэглэж байна;

- **Испани** улсын Эрүүгийн хуулиар хүнд гэмт хэрэгт “бүх эрхийг хасах, эсхүл 3-аас дээш жилээр тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6-аас дээш жилээр хасдаг” харин хөнгөн бол “тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 3 сараас 1 жилийн хугацаагаар” хасдаг.

Харин **ОХУ-ын** Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 6/ тодорхой албан

тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, мөн в/ тусгай, цэргийн болон хүндэт цол, зэрэг дэв, төрийн шагналыг хураах ялын төрлүүд заагджээ. Жишээ нь: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлд:

1. Тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрх хасах нь төрийн алба, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад албан тушаал хаших эсхүл тодорхой мэргэжлийн буюу бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоход оршино;

2. Тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартайгаар 1-5 жилийн хугацаагаар, нэмэгдэл ялын чанартайгаар 6 сараас 3 жилийн хугацаатай оногдуулна. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэмэлт ялаар 20 жил хүртэл хугацаагаар оногдуулна” гэжээ.

Манай урд хөрш болох **БНХАУ-ын** Эрүүгийн хуулийн “Эрүү шийтгэл” гэсэн 3 дугаар бүлгийн 32 дугаар зүйлд эрүү шийтгэлийг гол эрүү ба дагалдвар эрүү гэж хувааж, эрх хасах буюу “улс төрийн эрхийг нь хасах” ялыг дагалдвар эрүүгийн төрөл зүйл гэж үзсэн байна /үз. 34 дүгээр зүйл /хоёр/.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд “сонгох ба сонгогдох эрх, саналаа хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөтэй эрх, төрийн байгууллагад тушаал үүрэглэх эрх, улсын өмчийн гун-сы, аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгэмийн удирдах тушаал үүрэглэх эрх” хасах, 55 дугаар зүйлд “... хугацаа 1-5 жил байх”, 57 дугаар зүйлд “... алах шийтгэл ба хугацаагүй хорих шийтгэлээр шийтгэгдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нэг насаар нь хасах хэрэгтэй” гэж тус тус заажээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн “нэмэгдэл ял” гэсэн 44 дүгээр зүйлд “жолооны эрхийг хасах”, 45 дугаар зүйлд “төрийн алба хаших, сонгогдох болон саналын эрхийг хасах”, 70 дугаар зүйлд “мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах”, 69b дүгээр зүйлд “гадаад улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах” тухай заасан байна. Тухайлбал:

- хорих, торгох ял авсан этгээдийн бүх төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох буюу тодорхой ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг шүүх 1-6 сар хүртэл хугацаагаар хасаж болно /үз. 44 /1/;

- төрийн алба хаших, сонгогдох болон саналын эрхийг хасах ялыг ... багадаа 1 жилийн хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн хувьд төрийн алба хаших болон олон нийтийн сонгуультай холбоотой эрхийг 2-5 жилийн

хугацаагаар хасаж болно /үз. 45/;

- мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг 1-5 жил, хуульд заасан ялын хугацааны дээд хэмжээ нь гэмт хэрэг учруулж болох аюулаас хангалттай урьдчилан сэргийлж чадахгүй гэж шүүх үзвэл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хугацаагүй хасаж болно /үз. 70 /1¹.

Дани зэрэг бусад өндөр хөгжилтэй улс орнуудад тухайлбал: жолоодох эрхийг хасах ял шийтгэгдсэн бол согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхээ эхлээд үлээж шалгасны дараа тээврийн хэрэгсэл нь асаж замын хөдөлгөөнд оролцох арга хэмжээг шүүхээс 1-2 жилийн хугацаагаар авч хэрэгжүүлсэн байдаг.

2015 оны **Вьетнам** улсын Эрүүгийн хуулиар, цаазаар авах, хорих, торгох, бүх насаар хорих, сануулгын шийтгэл ял, олон нийтийн хяналтад байлгах, албадан гаргах ялаас гадна нэмэгдэл ялаар “... тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой ажил хийхийг 1-5 жил хориглох, зорчих эрхийг 1-5 жил хязгаарлах, иргэний тодорхой эрхийг 1-5 жил хасах” зэрэг эрхийн хязгаарлалт тогтоосон санкцуудтай.

БНАСАУ-ын 1987 оны Эрүүгийн хуулийн 28 дугаар зүйлд зааснаар “... албан тушаал хаших эрхийг хугацаагүй хасах, тодорхой хугацаагаар албан тушаал хаших эрхийг хасах гэх 2 төрлийн ял” байх ба уг ялыг “албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн байдал, дахин гэмт хэрэг үйлдэх боломж, нөхцөл зэргийг харгалзан шүүхээс хугацаагүй ба хугацаатай /3 жил хүртэл/ оногдуулж” болохоор заажээ².

БНСУ-д эрх хасах ял нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах /үз. 43 дугаар зүйл/ болон түдгэлзүүлэх /үз. 44 дүгээр зүйл/ гэж 2 ангилагддаг бөгөөд тус улсын Эрүүгийн хуулиар 1-15 жилийн хугацаагаар болон цаазаар авах, бүх насаар хорих зэрэг ялын хамт “... төрийн албан хаагч байх, сонгох, сонгогдох, захирал гэх мэт албан тушаал хаших” явдлыг хориглохоор заасан байна.

¹ Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль /хамтын бүтээл, орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл/. УБ., 2021., 112, 268-271., 362-382 дахь тал

² **Г.Гантөмөр**. БНАСАУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог. Гэмт явдалтай тэмцэх асуудал /сэтгүүл/. УБ., 2020., №2., 40 дэх тал.

Дээрх байдлаар эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлалын хүрээнд тухайлсан сэдвийг авч үзэж судлах нь олон талын мэдлэг, мэдээлэл өгөхийн зэрэгцээ зөв үзэл сэтгэлгээ, зарчимч чиглэл, зохистой хандлага тогтоход туслах учир таныг энэ асуудлаар илүү ихийг уншиж мэднэ гэдэгт итгэж байна.

Харьцуулсан судлал нь өөрийн улс орны үндэсний эрх зүйн тогтолцоог танин мэдэхэд туслаад зогсохгүй гадаадын бусад улс орнуудын эрх зүйн тогтолцоо, түүх, уламжлал, хууль зүйн онол, практик, соёл ахуйг ойлгоход дөхөм үзүүлж, эрх зүйн ижилсэх ба ондоосох шинж чанарыг судлах, үл мэдэх байдлыг арилгах, мэдлэгийн цар хүрээг тэлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн хөгжилд хүргэх зэрэгт онцгой нөлөө үзүүлдэг.

Иймд цаашид хөгжингүй улс орнуудын эрх зүйн тогтолцооны сонгодог жишиг, үндсэн чиглэлийг судлан үзэж харьцуулах, уламжлал шинэчлэлийг хослуулах, дэлхий дахины хөгжлийн хандлагад ойртох, рецепци оновчтой хийх, эрдэмтэн, судлаач нараа хөхиүлэн дэмжих, ном эрдэмд ач холбогдол өндрөөр өгч үнэлэх нэн шаардлагатай байна.

---o0o---